

## Монгол дахь ядуурлын дүр төрх, хүрээ тэлэлт

*Б. Эхицэцэг*

*Хүн Ам Зүйн Сургалт*

*Судалгааны Төвийн багш*

Монгол дахь ядуурлын байдалд үнэлэлт дүгнэлт өгөх зорилготой ЯБҮХ-ийн газрын сайн дурынхны хэсгээс зохион байгуулсан судалгааны мэдээллийг ашиглан энэхүү дүгнэлтийг гаргалаа. Энэхүү судалгааны гол зорилго нь НҮБ-ийн Үндэсний сайн дурынхны хөтөлбөр хэрэгжиж эхлээд байгаа аймаг дүүргүүдийн ядуу хүмүүсийн насны онцлог болон тэдгээрийн нийгэм, эдийн засаг, улс төр, эрүүл мэнд, амьжиргааны нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл олж авах зорилготой байсан. Энэ нь цаашилбал тухайн орон нутгийн ядуурал бууруулах үндсэн суурь болж өгөх юм. Уг судалгааны мэдээлэлийг үндэслэн дараахь асуудлуудыг дэвшүүлж, хариулт авахыг хичээсэн юм. Үүнд:

– Монголд хэн ядуу амьдарч байна вэ ?

– Тэд хаана, яаж амьдарч байна ?

– Энэ хүмүүс ядуу зүдүү байдлаа хэрхэн давж байна вэ? гэх мэт болно.

### Өрхийн бүтэц, шинж байдал

Өрх болон түүний бүтцийн талаарх ойлголтыг тодорхойлоход нэлээд нарийн түвэгтэй байдаг. Монголд сүүлийн хэдэн жилд өрхийн хэв маягт нэлээд өөрчлөлтүүд гарч эхэлсэн. Өмнөх жилүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд толгойсон өрхийн хувийн жин нэлээд нэмэгдэж байгаа бөгөөд хөдөөд энэ нь нэмэгдэх хандлага ажиглагдсаар байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх монголын нийт өрхийн тавны нэг хувийг эзлэж байна. Улсын хэмжээнд эмэгтэйчүүд тэргүүлсэн өрхийн хүн амын бараг 60 хувь нь ядуу байгаа бол эрэгтэйчүүд тэргүүлсэн өрхийн 31 хувь нь ядуу амьдарч байна.

Хүснэгт 1. Ядуу өрхийн бүтэц, өрхийн гишүүдийн тоогоор, байршлаар

	Хөдөөний баг	Аймгийн төв	Улаанбаатар	Нийт
<b>Өрхийн тэргүүн</b>				
Эрэгтэй	75.36	56.67	48.44	60.62
Эмэгтэй	24.64	43.33	45.17	39.38
<b>Өрхийн гишүүдийн тоо</b>				
Ганц бие	0.80	0.00	0.28	0.37
2-5 хүнтэй	33.51	33.06	37.22	34.56
6-8 хүнтэй	56.91	40.22	54.83	50.69
9-с дээш	8.78	26.72	7.67	14.39

Хүснэгт 1-с харахад судалгаанд хамрагдсан нийт ядуу өрхийн 61% нь эрэгтэй тэргүүлэгчтэй, 39% нь эмэгтэй тэргүүлэгчтэй байгаа ба түүний дотор Улаанбаатар хотод эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 45% хувь байгаа нь ихээхэн анхаарлыг татаж байна. Хүснэгт 1-с харахад нийт ядуу өрхийн 51% нь 6-8 ам бүлтэй байхад дөнгөж 0.4 нь ганц ам бүлтэй өрх байгаа бөгөөд


энэ нь ам бүл олонтой өрх ядууралд ихээхэн өртөж байгааг батлан харуулж байна. Энэхүү байдал хот, хөдөөд ялгаатай байгаа нь ч ажиглагдсан.

Хөдөөгийн ядуу өрхийн 66% –ийг 6 буюу түүнээс дээш ам бүлтэй өрх, 0.8%–ийг 1 ам бүлтэй өрх эзлэж байхад Улаанбаатар хотод энэ үзүүлэлт 61% болон 0.3% байна. Дундаж ам бүлтэй буюу 4–5 ам бүлтэй өрх хөдөөтэй харьцуулахад Улаанбаатарт нэлээд өндөр байсан байна.

Одоо өрхийн бүтцийг аймаг болон дүүргээр авч үзье. Бид судалгаандаа ядуу өрх олонтой аймаг дүүргүүдийг сонгосон. Судалгаанд сонгогдсон эдгээр аймаг дүүргүүд ядуурлын байдал нэлээд ялгаатай байсан. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх Хөвсгөл аймаг (42%), Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт (67%) хамгийн өндөр хувьтай байна. Дээрх эмэгтэй тэргүүлэгч олонтой аймаг, дүүргүүдэд ам бүлийн тоо эрэгтэй тэргүүлэгчтэй өрхтэй харьцуулахад өндөр байгаа хамаарал ажиглагдсан.

Эдгээрээс дүгнэн хэлэхэд ядуу хүмүүсийн дотор нэлээд хувийг эмэгтэйчүүд эзлэж байгаа бөгөөд энэ нь хотод ч, хөдөөд ч адилхан бөгөөд эмэгтэй хүн нийгэм, гэр бүлийнхээ өмнө давхар үүрэг хүлээж байдагтай нэлээд хэмжээгээр холбоотой. Эмэгтэйчүүд үр хүүхдээ төрүүлж өсгөхийн зэрэгцээ эрэгтэйчүүдийн нэгэн адил нийгмийн өмнө хөдөлмөрлөх үүргээ гүйцэтгэж давхар ачаалал үүрч байдаг нь шилжилтийн эдийн засгийн үед улам хүндэрч байна. Амьдрахын эрхээр бодит орлого улам бүр буурч байгаа өнөө үед эмэгтэйчүүд өөрийн хүч чадлыг дайчлан хөдөлмөрлөж байгаа ч мэдлэг, мэргэжил, авьяас чадвараа дээшлүүлэх өөрийгөө хөгжүүлэх цаг хугацаа, мөнгө хөрөнгө, дэмжлэг дутагдалтайгаас ядууралд илүүтэй өртөж байна.

Ядуу өрхүүдийн нас, хүйсний бүтцийг авч үзье.



Насны бүтцийг авч үзвэл ерөнхийдөө 0–16 насны хүн амын эзлэх хувь өндөр хувийг эзлэж байгаа бөгөөд хөдөөд энэ хувь хамгийн өндөр хувьтай байна. Үүнийг хөдөөд төрөлтийн түвшин хоттой харьцуулахад



өндөр байгаатай холбон тайлбарлаж болох юм. Ядуу өрхүүдийн дунд 0-16 насны бүлгийн хүн амын эзлэх хувь өндөр байна гэдэг нь ам бүл олонтой айл өрхүүд ядууралд илүү өртөж байгааг нотлон харуулж байна.

### Ядуу өрхүүдийн гэрлэлтийн байдал

Судалгаанд хамрагдсан ядуу өрхүүдийн 15-с дээш насны хүмүүсээс гэрлэлтийн байдлын мэдээг авсан. Нийт эрэгтэйчүүдийн 51%, эмэгтэйчүүдийн 43% нь гэрлэсэн. Гэрлэсэн хүн амын хувь аль ч газар ерөнхийдөө адилхан байна. Харин гэрлэлтийн байдлыг нь хүйсээр авч үзвэл ядуу өрхүүдийн эмэгтэйчүүдийн (Баянхонгор) 11.1% нь салсан, 5.7% бэлэвсэн байхад энэ үзүүлэлт эрэгтэйчүүдийн хувьд 3%, 3% байна. Салсан буюу бэлэвсэн эмэгтэйчүүдийн хувь нэмэгдэж байгаа нь өрх толгойлсон эмэгтэйн харьцаа өсөхөд зохих хэмжээгээр нөлөөлсөн болов уу.

Хүснэгт 2. Өрхийн гишүүдийн гэрлэлтийн байдал, хүйсээр, аймаг дүүргээр

Гэрлэлтийн байдал	Төв аймаг		Хөвсгөл аймаг		Баянхонгор аймаг		Чингэлтэй дүүрэг		Сонгино хайрхан	
	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Ганц бие	29.41	25.93	47.73	30.00	36.36	44.40	23.53	35.00	15.56	17.74
Гэрлэсэн	54.90	48.15	43.18	46.70	57.58	35.2	35.29	12.50	62.22	59.68
Тусдаа амьдардаг	0.00	3.70	0.00	3.33	0.00	3.70	5.88	7.50	4.44	3.23
Салсан	5.88	9.26	2.27	8.33	3.03	11.1	11.76	17.50	11.11	6.45
Бэлэвсэн	5.88	7.41	6.82	11.7	3.03	5.56	23.53	27.50	4.44	9.68
Хамт амьдардаг	3.92	1.85	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	2.22	1.61
Бусад	0.00	3.07	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	1.61

### Боловсрол, Сургууль завсардалт


Боловсролын түвшин нь хувь хүн болон нийгмийн хөгжлийн түвшинг үнэлэх, тодорхойлох чухал үзүүлэлт билээ. Тийм ч учраас дэлхий нийтэд хүний хөгжлийн индексийг тооцоход ашигладаг 3 үндсэн үзүүлэлтүүдийн нэг болж байна. Монгол улс боловсролын системийн хөгжлөөр дэлхийн хөгжиж буй улсуудын дотор дээгүүр байр суурь эзэлдэг билээ.

Гэтэл сүүлийн жилүүдэд ард түмний амьжиргааны түвшин доройтож, ядуу өрхийн тоо жилээс жилд нэмэгдэж байна. Орлого багатай ядуу айл өрхүүд нь мэдлэг чадвараа дээшлүүлэх, сурч боловсрох, эзэмшсэн мэргэжлээ өөрчлөх, шинэ мэргэжил эзэмшихэд төлбөрийн чадваргүйгээс чадварын ядууралд орох явдал нэмэгдэх хандлагатай байна. Сүүлийн үед ерөнхий боловсролын сургууль завсардах, сургуулиас гарах, сургуулийн насны хүүхэд сургуульд хамрагдахгүй байх зэргээр бидний нүдэнд ажиглагдаж байгаа хэлбэрээр ядууралд орогсдын тоо өссөөр байна.

Ийнхүү сургууль завсардалтын хувь нэмэгдсээр байгаа нь дараагийн шатны сургуульд суралцах боломж үгүйсч байгаа төдийгүй хүүхдүүд хөдөлмөрийн насанд хүрсэн үедээ зөвхөн биений хүчин шаардах энгийн ажил гүйцэтгэхээс хэтрэхгүй байдалд хүрнэ. Энэ нь нарийн мэргэжлийн хөдөлмөрийг бодвол бүтээмж доогуур, орлого багатай байдаг болохоор тодорхой хэмжээгээр орлогын болон чадварын ядууралд ороход хүргэх юм.



Зураг 2. Ядуу өрхийн хүүхдүүдийн сургууль завсардалтын шалтгаан



Сургуульд хамрагдалтыг байршлаар нь авч үзэхэд нэлээд ялгаатай байдал ажиглагдаж байна. Хөдөөд анхан шатны сургуульд хамрагдалтын түвшин харьцангуй доогуур байгаа бөгөөд энэ нь хэд хэдэн шалтгаантай гэж үзэж байна. Үүнд: малчдын дунд мал хувьчлалаар хувийн малтай болсноос хойш хүүхдүүдээ, ялангуяа хөвгүүдийг боловсрол эзэмшүүлэхээсээ илүү мал дээр гаргах сонирхол нь нэмэгдсэн. Хоёрдугаарт олон сумдад сургуулийн дотуур байр ажиллахгүй болсон буюу ажиллаж байгаа нь ч ихэвчлэн амьдралын наад захын нөхцлийг хангахааргүй тул хүүхдүүдээ сургуульд явуулахаас татгалзаж байна.

Сургууль завсардалтын шалтгааныг авч үзэхэд ядуу өрхүүд амьдралын боломж, мөнгө төгрөгний гачигдалтайн улмаас хүүхдүүдийнхээ дотуур байрны төлбөр, хичээлийн бэлтгэл, хувцас хунарыг хангаж чадахгүй сургуулиас нь завсардуулж байна. Нийт судалгаанд хамрагдсан ядуу өрхүүдийн 73 хувийг ийм шалтгаанууд эзлэж байна.

Сургууль завсардалтын шалтгаан нь хот, хөдөөд ялгаатай байна. Хотын ядуу өрхүүдийн хүүхдүүдийн дунд дээрх шалтгаануудаар хичээл сургууль завсардсан хувь мөн нэлээд хувийг эзлэж хөдөөтэй харьцуулахад сонирхолгүйн улмаас сургууль завсардсан гэж хариулсан хувь ч мөн өндөр байна. Хүйсээр авч үзвэл ядуу өрхүүдийн хүүхдүүдээс эрэгтэй хүүхдүүдийн сургуулиас завсардаж байгаа хувь нэлээд өндөр байгаа нь анхаарал татаж байна. Малыг хувьчилсны дараа хүүхдийн хөдөлмөрийн (ялангуяа эрэгтэй хүүхдийн) хэрэгцээ шаардлага мэдэгдэхүйц нэмэгджээ. Хот сууринд сургуулийн сурагчдын дотор хүйсийн ялгаа их биш байгаа бол хөдөөд аль ч ангилалын өрхийн сургуульд сурч буй эрэгтэй хүүхдийн тоо эмэгтэйдээсээ цөөн байна.

Дээрх байдлаас дүгнэн үзэхэд сургалтын төлбөр(дотуур байрны), хүүхдийн хувцасны үнэ нэмэгдсэн, сургуулийн орчны байдал нэлэнхүйдээ

муудсан зэрэг нь хүүхдээ сургуульд оруулахгүй болоход нөлөөлсөн хүчин зүйлүүд гэж үзэж байна.

### Өрхийн орлого, зарлагын бүтэц

Судалгаанд хамрагдсан ядуу өрхийн орлогод цалингийн эзлэх хувийн жин 33% , тэтгэвэр тэтгэмжийнх 20%, ах дүүсийн дэмжлэг 11% –ийг эзлэж байна. Үүнийг хот, хөдөөгийн ялгаагаар авч үзвэл хотод ядуу өрхүүдийн орлогын эх үүсвэрийн нэлээд хувийг цалин эзлэж байхад хөдөөгийн өрхүүдийн орлогын гол эх үүсвэр нь ХАА–н бүтээгдэхүүн, малын ашиг шимийн орлогоос бүрдэж байна. Хот хөдөөгийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор тэдний орлогын бүрэлдэхүүн хэсгүүд ялгаатай байна. Ядуу өрхүүд хөдөөтэй харьцуулахад хотод цалин тэтгэврээс гадна жижиг наймаа эрхлэх, хаягдал цуглуулах зэргээс орлого олж байна гэж хариулсан хувь өндөр байна.

Одоо мөнгөн зарлагын бүтцийг авч үзье.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн мөнгөн зарлагад хүнсний зүйлийн зарлага дунджаар 79% –ийг эзлэж байна. Энэ нь хот, хөдөөд ялгаагүй байгаа бөгөөд ядуу өрхүүд мөнгөн орлогынхоо дийлэнх хэсгийг хүнсэнд хэрэглэж бусад төрлийн барааг худалдан авах боломж хомс байна.


Зураг 3. Ядуу өрхүүдийн орлогын эх үүсвэр



Ядуу өрхийн орлогын бүтэцтэй хамт, тэдний зарлагын бүтэцтэй хамт үзвэл, ядуу өрхүүдийн 79% нь өдөр бүр, 20% нь 7 хоногт 1-2 удаа махан хоол хэрэглэж байна. Байрны хувьд ихэнх нь нутаг ажилтан бусадгүй. Харин зүүн цэгт энэ хувь эрс багасж ядуу өрхүүдийн нэлээд хувь (38%) нь 7 хоногт 1-2 удаа махан хоол идэж байна гэж хариулсан. Энэ нь зүүн махны үнэ нэмэгдэх, хүнсний ногооны хангамж хямралттай холбоотой байж болох юм. Хөдөөд зүүн идэж байгаа махны хэрэгцээ өндөр байгаа учраас ядуу өрхүүд нь зүүнээ голдуу шатаан нэр хэрэглэхтэй холбоотой. Ядуу өрхүүдийн хэрэглэж буй



Зураг 4. Ядуу өрхүүдийн орлогын зарцуулалт



Судалгаанд хамрагдсан 15-с дээш насны болон одоогоор сургуульд суралцаагүй байгаа хүмүүсээс тэдний мэргэжил болон ядуу зүдүүгээс гарахын тулд тэдний юу хийж чадах талаар асуусан.

Мэргэжлийн байдлыг авч үзэхэд ядуу өрхийн гишүүдийн нэлээд нь мэргэжилгүй, эмэгтэй тэргүүлэгчтэй ядуу өрхийн гишүүд эрэгтэй тэргүүлэгчтэй өрхтэй харьцуулахад мэргэжлийн байдал доогуур байна. Нийт ядуу өрхийн гишүүдийн 40.38% (эм.тэр), 47.6% (эр. тэр) нь мэргэжлийн ажлыг хийж чадна гэж хариулсан ба мөн гар урлал, оёдол мужааны ажлыг хийх сонирхолтой хүмүүсийн хувь өндөр байна.

Энэ бүгдээс харахад ядуучуудын олонхи нь эрх ашиг хувь заяаныхаа төлөө өөдрөгөөр төсөөлж, түүндээ хүрэхийн төлөө тэмцэж ажиллах чадвартай хүмүүс гэдгийг хүндэлж тэдэнд туслах хэрэгтэй болов уу.

Ядуучууд бол олдсоноо идчихдэг маргаашаа боддоггүй богино ухаантнууд, тэд дээд зэргийн залуу, аминдаа арчаагүй хүмүүс гэсэн ойлголт байдаг. Дээрх судалгаанаас харахад тэд тийм хүмүүс огтхон ч биш харин өөрсдийн алс ирээдүйн төлөө муугаар биш, өөдрөгөөр бодож төсөөлдөг байна.

Хүснэгт 3. Ядуу өрхийн гишүүдийн мэргэжил, хөдөлмөрийн чадвар, аймаг дүүргээр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр

	Төв аймаг		Хөвсгөл аймаг		Баянхонгор аймаг		Чингэлтэй дүүрэг		Сонгино хайрхан	
	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
<b>Мэргэжлийн байдал</b>										
Мэргэжилтэй	45.45	43.75	40.74	36.92	50.00	51.61	60.00	42.00	51.09	47.75
Мэргэжилгүй	54.55	56.25	59.26	63.08	50.00	48.39	40.00	58.00	48.91	52.25
<b>Ажил хийх чадвар</b>										
Чадваргүй	32.73	54.69	55.56	50.77	31.58	25.81	40.00	36.00	25.00	18.46
Мэргэжлийн ажил хийх	12.73	4.69	7.41	12.31	28.95	30.65	20.00	10.00	40.38	47.60
Мал маллах	9.09	10.94	3.70	4.62	2.63	4.84	0.00	2.00	0.00	0.00
Газар тариалан	9.09	9.38	0.00	0.00	5.26	3.23	0.00	0.00	1.92	0.00
Оёдол мужаан	14.55	10.94	3.70	9.23	13.16	16.13	4.00	32.00	15.38	13.85
Гар урлал	5.45	1.65	1.85	7.69	2.63	4.84	8.00	4.00	5.77	4.62
Биений хүчний ажил	5.45	3.13	20.37	0.00	15.79	8.06	24.00	10.00	9.62	13.85
НААҮ	3.64	3.13	1.85	10.77	0.00	4.84	0.00	2.00	0.00	1.54
Бусад	7.27	1.56	5.56	4.62	0.00	1.61	4.00	4.00	1.92	0.00

### Өрхийн амьдралын нөхцөл байдал

Судалгаанд өрхийн амьжиргааны түвшин, хэв маяг нөхцлийг тодорхойлох зорилгоор холбогдох асуултуудыг багтаасан бөгөөд үр дүнг байршлын ялгаатайгаар харууллаа.


Монгол цаг уурын хувьд өвлийн улирал нь бараг 5 сар үргэлжилдэг, агаарын дундаж температур  $-20$  хэм байдаг учраас хот, хөдөө хаана ч орон сууцны нөхцөл асар их хэрэгтэй байдаг. Хэдийгээр Монголд халаалт, ундны ус, гэрэл, тээврийн үйлчилгээ өргөн дэлгэрсэн ч ядуус эдгээр үйлчилгээнд хамрагдах боломжоор тааруу байна. Ядуу өрхүүдийн 50-иад хувь нь гэрт амьдарч байна. Хот сууринд ч гэсэн 35 хувь нь гэрт амьдарч байна. Өрхийн сууцны хэлбэр нь тухайн өрхийн халаалт, цэвэр усны хэрэглээтэй нягт уялддаг. Нийт ядуу өрхийн 62% нь худгаас, 32% нь голоос усны хэрэгцээгээ хангадаг байна. Ядуу өрхүүд усан хангамжийн төвлөрсөн системд хамрагдах боломж муутай байгаа бөгөөд энэ нь тэдний дунд усаар дамжин дэлгэрэх өвчний улмаас нас баралт нэмэгдэхэд хүргэж болох талтай. Хөдөөгийн ядуу өрхүүд төвлөрсөн системд хамрагдах нөхцөл маш доогуур, харин хөдөөтэй харьцуулахад хотод энэ хувь арай өндөр байна. Хөдөөнөөс зөвхөн Хөвсгөл аймагт 2.56%, харин Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг 6.67%, Сонгинохайрхан дүүрэгт 5.88% нь төвлөрсөн халуун, хүйтэн усан хангамжтай байна.

Ядуу өрхийн махны хэрэглээг өвөл, зунаар авч үзье. Нийт ядуу өрхүүдийн 54% нь өдөр бүр, 20% нь 7 хоногт 1-2 удаа махан хоол хэрэглэж байна. Байршлын хувьд нэг их ялгаа ажиглагдсангүй. Харин зуны цагт энэ хувь эрс багасаж ядуу өрхүүдийн нэлээд хувь (38%) нь 7 хоногт 1-2 удаа махан хоол идэж байна гэж хариулжээ. Энэ нь зунд махны үнэ нэмэгддэг, хүнсний ногооны хангамж нэмэгддэгтэй холбоотой байж болох юм. Хөдөөд зунд идэж байгаа махны хэрэглээ өвлийнхөөсөө доогуур байгаа нь зундаа голдуу цагаан идээ хэрэглэдэгтэй холбоотой. Ядуу өрхүүдийн хэрэглэж буй




хоол хүнсний хэрэглээг авч үзэхэд голдуу гурилтай хоол, бантан, гамбир зэргээр хооллож байна. Хүний хоолны илчлэгийн хэмжээ олон нэр төрлийн бүтээгдэхүүнээс норм ёсоор бүрдэх ёстой атал ядуу өрхүүдийн хувьд дийлэнх хэсэг нь гурил, мах 2-оос илчлэгээ бүрдүүлж байна. Ийнхүү ядуу хүмүүсийн хоол тэжээлийн наад захын хэм хэмжээ мөрдөгдөж чадахгүйд хүрч эмгэг өвчтэй, согогтой болж өсөж байна.

Зураг 5. Ядуу өрхүүдийн ундны усны хангамж



Зураг 6. Ядуу өрхүүдийн голчлон хэрэглэж байгаа хоол





Хүснэгт 4. Ядуу өрхийн амьдарч буй нөхцөл байдал, байршлаар						
	Төв аймаг	Хөвсгөл аймаг	Баянхонгор аймаг	Чингэлтэй дүүрэг	Сонгино хайрхан дүүрэг	Нийт
<b>Байр/орон сууц</b>						
Гэр	61.54	33.33	62.75	53.33	26.47	
Хувийн байшин	20.51	33.33	15.69	26.67	23.53	
Айлын байр хөлсөлж	0.00	17.95	17.65	6.67	20.59	
Орон сууц	15.38	0.00	3.92	6.67	8.82	
Модон байшин	2.56	0.00	0.00	6.67	20.59	
Бусад	0.00	15.38	0.00	0.00	0.00	
<b>Уидны усны хангамж</b>						
Гол	17.95	46.15	64.71	13.33	0.00	32.12
Худаг	82.05	48.72	27.45	60.00	91.18	62.18
Цас борооны ус	0.00	0.00	5.88	0.00	2.94	2.07
Төвлөрсөн хал. хүйтэн	0.00	2.56	0.00	6.67	5.88	2.59
Төвлөрсөн хүйтэн	0.00	2.56	1.96	0.00	0.00	1.04
<b>Махны хэрэгцээ (өвөл)</b>						
7 хоногт 1-2 удаа	17.95	33.33	7.84	13.33	35.29	20.73
7 хоногт 3-4 удаа	17.95	10.26	21.57	10.00	8.82	14.51
7 хоногт 5-6 удаа	10.26	7.69	5.88	23.33	14.71	11.40
7 хоногт 7-оос дээш	53.85	48.72	64.71	53.33	41.18	53.37
<b>Махны хэрэгцээ (зуу)</b>						
7 хоногт 1-2 удаа	20.51	58.97	43.14	20.00	44.12	38.34
7 хоногт 3-4 удаа	41.03	10.26	33.33	23.33	8.82	24.35
7 хоногт 5-6 удаа	10.26	0.00	9.80	26.67	14.71	11.40
7 хоногт 7-оос дээш	28.21	30.77	13.73	30.00	32.35	24.91
<b>Өдрийн хоолны хэрэглээ</b>						
нэг удаа	43.59	17.95	7.84	36.67	73.53	33.16
хоёр удаа	38.46	53.85	60.78	56.67	20.59	47.15
гурван удаа	17.95	28.21	31.37	6.67	5.88	19.69
<b>Голчлон хэрэглэдэг хоол</b>						
Гурилтай хоол	32.05	15.39	34.31	36.66	41.17	31.61
Бантан	11.54	47.44	14.71	25.00	29.41	24.87
Хайрсан цай	21.80	11.54	12.76	0.00	13.24	12.44
Талх, боорцог	16.67	3.85	2.94	10.00	4.41	7.25
Гамбир	14.09	11.53	16.66	28.33	11.77	16.06
Цагаан идээ	0.00	6.40	18.63	0.00	0.00	6.21
Бусад	3.85	3.85	0.00	0.00	0.00	1.56
<b>Дүн</b>	<b>100.00</b>	<b>100.00</b>	<b>100.00</b>	<b>100.00</b>	<b>100.00</b>	<b>100.00</b>

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлоход удаан эдэлгээт барааны хэрэглээний байдал чухал үүрэгтэй байдаг. Ядуу өрхүүдийн удаан эдэлгээт барааны хэрэглээг үзэхэд радио 37%, индүү 26.7%, хөргөгч 17%-ийг эзлэж байна. Байршлаар авч үзвэл телевиз, индүү, хөргөгч гэсэн цахилгаан барааны эзлэх хувь хотын ядуу өрхүүдийн дунд хөдөөнийхнөөс өндөр байна.

Ядуу өрхүүд ядарч, өлсөж зовохын эрхэнд өөрсдийн амьдарч буй гэр орон, эд зүйлсээ заран амьдарч байна. Сүүлийн нэг жилийн хугацаанд судалгаанд хамрагдсан өрхүүдийн 12% нь өөрсдийн эд хогшил, 5.3% нь хувийн байшин гэр, 4.2% нь малаа заран амьдарч байна гэжээ.

Хүснэгт 5. Ядуу өрхийн эдийн засгийн зарим үзүүлэлтүүд, байршлаар

	Төв аймаг	Хөвсгөл аймаг	Баянхонгор аймаг	Чингэлтэй дүүрэг	Сонгинохайрхан дүүрэг
<b>Өрхийн эдийн засгийн түвшин</b>					
Гурил будаа мөнгө зээлдэг	82.05	84.62	88.24	46.67	88.24
Зээлдэггүй	17.95	15.38	11.76	53.33	11.76
<b>Зээлдэггүй шалтгаан</b>					
Зээлэх хүн олддоггүй	100.00	33.33	83.33	12.50	0.00
Зээлэхийг хүсдэггүй	0.00	50.00	16.67	37.50	0.00
Болоод л байдаг	0.00	16.67	0.00	50.00	100.00
<b>Хаанаас зээлдэг</b>					
Ажлын газраас	9.38	6.06	8.89	7.14	16.67
Орон нутгийн захиргаанаас	9.38	9.09	4.44	0.00	0.00
ТББ-аас	0.00	0.00	0.00	0.00	10.00
Хувь хүнээс	71.88	84.85	82.22	92.86	73.33
Бусад	9.36	0.00	4.45	0.00	0.00
<b>Өр</b>					
Өртэй өрх	58.97	71.79	68.63	46.67	76.47
Өргүй өрх	41.03	28.21	31.37	53.33	23.53
<b>Дүн</b>	100.00	100.00	100.00	100.00	100.00

Нийт судалгаанд хамрагдсан ядуу өрхүүдийн 70-аад хувь нь өр ширтэй байна. Тэдэнд өнөөдөр ажлын байр байхгүй орон нутаг нь тэр бүр тусламж дэмжлэг үзүүлж чадахгүй байгаагаас үүдэн голдуу хувь хүнээс (70-80 хувь нь) зээл авч амьдарч байна. Ядуу өрхүүдийн 80-аад хувь нь гурил будаа мөнгө төгрөг зээлдэг гэжээ. Өнөөдөр ядуучууд орлогогүйн улмаас мөнгө төгрөг, хоол унд зээлье гэсэн ч зээлэх хүн олддоггүй гэсэн хариулт өндөр хувьтай байна. Энэ нь ядуучуудаас эргээд авах нь бараг байдаггүйтэй холбоотой. Харин энд тэмдэглэхэд Улаанбаатарт хөдөөтэй харьцуулахад мөнгө төгрөг зээлэх сонирхол бага байгаа үзэгдэл ажиглагдлаа. Магадгүй энэ нь хотжих тусмаа хүмүүсийн бие даан амьдрах байдал ихэсдэгтэй холбоотой болов уу гэж санаж байна.